



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ МУЗЕЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/194/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261628 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Аудитор: П.Амарсанаа
Утас: 261740 Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Уваа уул Аудит ХХК
Захирал: Ч.Мөнхтуяа
Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт	20
4.1 Залруулсан алдаа	20
4.2 Төлбөрийн акт.....	20
4.3 Зөвлөмж	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын хоёрдугаар газар
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
НА	Нотлох ажил
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ МУЗЕЙН
ЗАХИРАЛ Л.ЖАРГАЛ ТАНАА

2022.02.25 № 07/447
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монголын үндэсний музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Монголын үндэсний музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар залруулагдаагүй 50,785.7 мянган төгрөгийн зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.3, Нийцсэн бөгөөд зохистой байх, Эрх ба үүрэг, Тохиолдсон байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	304,240,940.80	225,796,926.20
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	850,139.90
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	00.00	850,139.90
31130	Нэмэлт санхүүжилт	00.00	850,139.90
35	БАРАА МАТЕРИАЛ	304,240,940.80	224,946,786.30
351	Түүхий эд материал	00.00	183,310.00
35130	Эм боох материал	00.00	183,310.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	58,699,871.50	53,819,924.00
354	Хангамжийн материал	245,541,069.30	170,943,552.30
35410	Бичиг хэргийн материал	5,063,400.00	7,263,200.00
35420	Аж ахуйн материал	2,286,730.00	1,819,180.00
35470	Бусад хангамжийн материал	238,190,939.30	161,861,172.30
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,877,280,440.48	8,680,299,561.30
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,877,280,440.48	8,680,299,561.30
392	Биет хөрөнгө	8,768,193,362.74	8,571,395,816.92
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,857,144,733.00	3,857,144,733.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(130,036,657.92)	(195,991,504.68)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	87,133,600.00	18,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(70,133,600.00)	(3,750,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,072,259,733.90	1,064,614,033.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	(718,969,728.55)	(801,741,786.42)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	395,161,463.00	395,644,129.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(115,288,334.25)	(153,445,942.04)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	4,363,877,417.00	4,363,877,417.00
39217	Ном	27,044,736.56	27,044,736.56
393	Биет бус хөрөнгө	109,087,077.74	108,903,744.38
39301	Програм хангамж	2,995,000.00	2,995,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,704,722.26)	(2,888,055.62)
39303	Бусад биет бус хөрөнгө	108,796,800.00	108,796,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,181,521,381.28	8,906,096,487.50
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,181,521,381.28	8,906,096,487.50
51	Засгийн газрын хувь оролцоо	9,181,521,381.28	8,906,096,487.50
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,363,714,164.40	1,363,714,164.40
51101	Өмч: - төрийн	1,363,714,164.40	1,363,714,164.40
512	Хуримтлагдсан үр дүн	2,281,331,140.31	2,005,906,246.53
51210	Өмнөх үеийн үр дүн	2,401,476,202.64	2,281,331,140.31
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	(275,424,893.78)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,536,476,076.57	5,536,476,076.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9,181,521,381.28	8,906,096,487.50

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,297,741,038.78	1,221,387,880.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	90,139,815.22	2,137,066.60
120	Нийтлэг татварын бус орлого	90,139,815.22	2,137,066.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	88,568,000.00	2,137,066.60
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	88,568,000.00	00.00
120009	Бусад орлого	1,571,815.22	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	00.00	2,137,066.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,207,601,223.56	1,219,250,813.90
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,146,735,000.00	1,078,977,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,146,735,000.00	1,078,977,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	60,866,223.56	140,273,413.90
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,448,000.00	90,218,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	56,418,223.56	50,054,513.90
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,417,886,101.11	1,446,713,157.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,417,886,101.11	1,446,713,157.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,206,458,140.80	1,366,349,192.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	752,790,994.90	800,493,298.79
210101	Үндсэн цалин	577,369,094.03	613,491,321.21
210102	Нэмэгдэл	136,022,900.87	125,545,347.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,399,000.00	61,456,629.78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,274,123.27	107,226,663.30
210201	Тэтгэврийн даатгал	64,850,946.67	76,753,377.76
210202	Тэтгэмжийн даатгал	7,706,724.94	8,035,234.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,111,205.52	6,256,828.02
210204	Ажилгүйдлийн даатгал	1,314,404.17	1,360,895.71
210205	Эрүүл мэндийн даатгал	14,290,841.97	14,820,326.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,134,030.28	39,656,300.00
210301	Гэрэл, цахилгаан	20,368,090.32	13,747,106.50
210302	Түлш, халаалт	21,843,322.14	23,429,201.50
210303	Цэвэр, бохир ус	1,922,617.82	2,479,992.00
2104	Хангамж, бараа материалын зардал	66,117,693.56	108,252,947.20
210401	Бичиг хэрэг	7,132,690.36	13,714,090.00
210402	Тээвэр, шатахуун	1,165,200.00	381,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,946,830.02	3,422,214.70
210404	Ном, хэвлэл	3,775,980.00	11,102,307.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,031,000.00	6,818,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	47,065,993.18	36,413,082.00

Монголын үндэсний музейн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210408	Бараа материал акталсны зардал	00.00	36,401,753.00
2105	Нормативт зардал	2,139,160.00	171,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,139,160.00	171,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,964,747.00	528,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,097,200.00	10,000.00
210604	Урсгал засвар	15,867,547.00	518,000.00
2107	Томилолт, зочны зардал	250,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	250,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,382,320.00	115,065,154.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,848,000.00	108,016,492.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,018,500.00	2,090,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	98,010.00	368,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	551,860.00	575,782.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	138,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,494,250.00	1,778,550.00
210807	Газрын төлбөр	658,200.00	658,200.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	713,500.00	1,439,620.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	205,405,071.79	194,955,829.17
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,591,257.00	3,274,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	266,499.10	1,036,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	199,547,315.69	190,644,929.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	211,427,960.31	80,363,965.21
2132	Бусад урсгал шилжүүлэг	77,576,000.00	1,455,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	77,166,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410,000.00	1,455,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	133,851,960.31	78,908,365.21
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	133,851,960.31	78,908,365.21
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(120,145,062.33)	(225,325,277.17)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	50,099,616.61
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	10,922,916.61
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	39,176,700.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	(50,099,616.61)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(120,145,062.33)	(275,424,893.78)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,363,714,164.40	5,536,476,076.57	1,976,025,755.34	8,876,215,996.31
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,363,714,164.40	5,536,476,076.57	1,976,025,755.34	8,876,215,996.31
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	427,114,171.72	427,114,171.72
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,363,714,164.40	5,536,476,076.57	2,281,331,140.31	9,181,521,381.28
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,363,714,164.40	5,536,476,076.57	2,281,331,140.31	9,181,521,381.28
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(275,424,893.78)	(275,424,893.78)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,363,714,164.40	5,536,476,076.57	2,005,906,246.53	8,906,096,487.50

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,207,745,223.56	1,219,250,813.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,207,745,223.56	1,219,250,813.90
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,146,735,000.00	1,078,977,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,146,735,000.00	1,078,977,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	61,010,223.56	140,273,413.90
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,448,000.00	90,218,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	56,562,223.56	50,054,513.90
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,198,344,223.56	1,215,950,774.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,198,344,223.56	1,215,950,774.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	986,916,263.25	1,135,586,808.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	763,128,084.58	800,493,298.79
210101	Үндсэн цалин	554,411,082.65	614,713,350.98
210102	Нэмэгдэл	168,773,013.60	124,637,359.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,943,988.33	61,142,588.63
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,363,442.37	107,226,663.30
210201	Тэтгэврийн даатгал	59,221,930.35	76,753,377.76
210202	Тэтгэмжийн даатгал	9,203,629.90	8,035,234.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,901,878.35	6,256,828.02
210204	Ажилгүйдлийн даатгал	1,180,305.56	1,360,895.71
210205	Эрүүл мэндийн даатгал	12,855,698.21	14,820,326.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,303,684.28	39,156,300.00
210301	Гэрэл, цахилгаан	20,537,744.32	13,747,106.50
210302	Түлш, халаалт	21,843,322.14	22,929,201.50
210303	Цэвэр, бохир ус	1,922,617.82	2,479,992.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,629,351.02	47,786,162.70
210401	Бичиг хэрэг	2,766,560.00	6,939,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,686,200.00	1,541,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,946,830.02	3,552,214.70
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,031,000.00	8,085,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,198,761.00	27,667,248.00
2105	Нормативт зардал	2,442,370.00	1,927,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,442,370.00	1,927,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,411,461.00	1,917,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,494,200.00	1,399,000.00
210604	Урсгал засвар	16,917,261.00	518,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,559,020.00	134,017,584.00

Монголын үндэсний музейн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,843,600.00	119,444,792.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	98,010.00	368,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	766,860.00	435,482.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	235,000.00	138,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,344,250.00	3,349,600.00
210807	Газрын төлбөр	658,200.00	798,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	6,613,100.00	7,483,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,078,850.00	3,062,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	993,600.00	724,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,085,250.00	2,337,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	211,427,960.31	80,363,965.21
2132	Бусад урсгал шилжүүлэг	77,576,000.00	1,455,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	77,166,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410,000.00	1,455,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	133,851,960.31	78,908,365.21
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	133,851,960.31	75,014,884.34
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг /нэмэлт/		3,893,480.87
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	9,401,000.00	3,300,039.90
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,401,000.00	2,449,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,401,000.00	2,449,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,401,000.00	2,449,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,401,000.00	2,449,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(9,401,000.00)	(2,449,900.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	850,139.90
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	850,139.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,078,977,400.00	1,003,962,515.66	75,014,884.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,078,977,400.00	1,003,962,515.66	75,014,884.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,078,633,000.00	1,003,618,115.66	75,014,884.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	844,275,000.00	782,126,081.79	62,148,918.21
210101	Үндсэн цалин	556,524,400.00	596,346,133.98	(39,821,733.98)
210102	Нэмэгдэл	210,890,600.00	124,637,359.18	86,253,240.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	76,860,000.00	61,142,588.63	15,717,411.37
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,977,200.00	102,512,387.17	11,464,812.83
210201	Тэтгэврийн даатгал	80,206,100.00	72,039,101.63	8,166,998.37
210202	Тэтгэмжийн даатгал	8,442,800.00	8,035,234.94	407,565.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,754,200.00	6,256,828.02	497,371.98
210204	Ажилгүйдлийн даатгал	1,688,600.00	1,360,895.71	327,704.29
210205	Эрүүл мэндийн даатгал	16,885,500.00	14,820,326.87	2,065,173.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,924,200.00	36,924,200.00	-
210301	Гэрэл, цахилгаан	13,850,600.00	13,747,106.50	103,493.50
210302	Түлш, халаалт	20,479,800.00	20,697,101.50	(217,301.50)
210303	Цэвэр, бохир ус	2,593,800.00	2,479,992.00	113,808.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,324,600.00	16,316,212.70	8,387.30
210401	Бичиг хэрэг	1,908,700.00	1,907,600.00	1,100.00
210402	Тээвэр, шатахуун	1,081,700.00	1,081,700.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,382,500.00	3,375,214.70	7,285.30
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,098,500.00	3,098,500.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,853,200.00	6,853,198.00	2.00
2105	Нормативт зардал	1,927,200.00	1,927,200.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,927,200.00	1,927,200.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	518,000.00	518,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,954,200.00	60,561,434.00	1,392,766.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	47,824,100.00	47,488,642.00	335,458.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	825,400.00	368,010.00	457,390.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	774,600.00	435,482.00	339,118.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	398,400.00	138,000.00	260,400.00
210806	Мэдээлэл, технологийн	3,350,000.00	3,349,600.00	400.00

Монголын үндэсний музейн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	үйлчилгээ			
210807	Газрын төлбөр	798,500.00	798,500.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,983,200.00	5,983,200.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,732,600.00	2,732,600.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	724,800.00	724,800.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,007,800.00	2,007,800.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	344,400.00	344,400.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	344,400.00	344,400.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	344,400.00	344,400.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,078,977,400.00	1,003,962,515.66	75,014,884.34
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,078,977,400.00	1,003,962,515.66	75,014,884.34
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,078,977,400.00	1,003,962,515.66	75,014,884.34
	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-		-
	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл			
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	61	61	-
620001	Удирдах ажилтан	1	1	-
620002	Гүйцэтгэх ажилтан	41	41	-
620003	Үйлчлэх ажилтан	19	19	-

2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		139,423,274.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		139,423,274.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		134,418,593.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		18,367,217.00
210101	Үндсэн цалин		18,367,217.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		4,714,276.13
210201	Тэтгэврийн даатгал		4,714,276.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		2,232,100.00
210302	Түлш, халаалт		2,232,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал		31,469,950.00
210401	Бичиг хэрэг		5,031,900.00
210402	Тээвэр, шатахуун		460,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		177,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		4,987,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		20,814,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		3,848,900.00
21601	Багаж техник хэрэгсэл		3,848,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		73,456,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		71,956,150.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		1,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		330,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		330,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		5,004,680.87
2132	Бусад урсгал шилжүүлэг		1,111,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,111,200.00
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг /нэмэлт/		3,893,480.87
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		140,273,413.90
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		140,273,413.90
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		90,218,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		50,054,513.90
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		850,139.90

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монголын үндэсний музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулах, хөрөнгийн ангилал зөв бүртгэх, нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 25-наас 2022 оны 2 дугаар сарын 20-ны хооронд Уваа уул аудит ХХК-ийн аудитор Ц.Саранцэцэг, аудиторын туслах Э.Номинчулуун, Г.Сампилмаа нар гүйцэтгэж, хяналтыг захирал Ч.Мөнхтуяа хэрэгжүүлсэн.

Монголын үндэсний музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 6 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Монголын Үндэсний музейн зорилго нь монгол үндэстний соёлын биет болон биет бус өвийг эрэн сурвалжлах, олж цуглуулах, бүртгэн баримтжуулах, сэргээн засварлах, хадгалж хамгаалах, утга агуулга, гарал үүслийг нь шинжлэх ухаанчаар судлан тодорхойлох, хойч үедээ уламжлуулж, олон нийтэд дэлгэн үзүүлж сурталчлан таниулах, оюуны тодорхой эрэлт хэрэгцээг хангах улмаар нийгмийн хөгжилд үр нөлөө үзүүлэхэд оршино.

Тайлант онд АНУ-ын Элчин сайдын Соёлын өвийн сангийн тэтгэлгээр "Монголын яаралтай хамгаалах шаардлагатай нэхмэл цуглуулга ба өв уламжлалыг хадгалан хамгаалах" төсөл хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Музейн тухай хууль;
- Соёлын тухай хууль;
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Монголын үндэсний музей нь БСШУС-ын 2017 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн “Бодлогын баримт бичиг, журам батлах тухай” А/40 тоот тушаалын хүрээнд бэлтгэсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллаж байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Соёлын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар нь тус байгууллагын "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийж, дараах зөвлөмжүүдийг өгсөн байна. Үүнд:

- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу гаргах ёстой "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг шилэн дансанд байршуулах,
- Тушаал байршуулахдаа зарим мөнгөн дүн тодорхойгүй, хавсралтыг оруулаагүй байгааг цаашид анхаарах.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монголын үндэсний музейн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,417,886.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 14,178.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Монголын үндэсний музейн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 275,209.4 мянган төгрөгөөр буюу 3.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00.00	850.1	850.1
Бараа материал	304,240.9	224,946.8	(79,294.1)
Үндсэн хөрөнгө	8,877,280.4	8,680,299.6	(196,980.8)
Нийт хөрөнгө	9,181,521.4	8,906,096.5	(275,424.9)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	9,181,521.4	8,906,096.5	(275,424.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	9,181,521.4	8,906,096.5	(275,424.9)

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Жилийн эцэст кассын орлогоос 850.1 мянган төгрөгийг харилцах дансанд төвлөрүүлээгүйгээс үлдэгдэлтэй;

- Бараа материал дансны үлдэгдэл 224,946.8 мянган төгрөг болж, 79,294.2 мянган төгрөгөөр буурсан нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор бараа материал худалдан авч зарцуулсан, Соёлын өвийн төвд 39,176.7 мянган төгрөгийн бараа материал шилжүүлж, 36,401.7 мянган төгрөгийн хангамжийн материал акталсан;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,680,299.6 мянган төгрөг болж, 196,980.8 мянган төгрөгөөр буурсан нь 2,449.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, ТӨБЗГ-ын 2021 оны 138 дугаар тогтоолын дагуу 69,133.6 мянган төгрөгийн 3 авто тээврийн хэрэгсэл акталж устгасан, Соёлын өвийн төвд 11,750.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шилжүүлсэн, 5,274.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл шилжүүлэн авсан, тайлант хугацаанд 190,429.5 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан;
- Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ дансны үлдэгдэл 8,906,096.5 мянган төгрөг болж, 275,424.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Монголын үндэсний музейн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос оноос 76,353.2 мянган төгрөгөөр буюу 5.9 хувиар буурсан байна. Материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

Өмнөх оны үзүүлэлтээс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 67,757.6 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 86,913.6 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 6,363.7 мянган төгрөгөөр буурч, дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан хөрөнгө 85,770.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Нийт зардлыг өмнөх онтой харьцуулахад 78,926.7 мянган төгрөгөөр буюу 5.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 91,682.8 мянга, унаа хоолны хөнгөлөлт 22,057.6 мянган төгрөг, ном, хэвлэл 7,326.3 мянган төгрөгөөр өссөн, гэрэл, цахилгааны зардал 6,620.98 мянган төгрөгөөр буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны санхүүжилтийн эх үүсвэрийг 1,179,570.9 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 1,179,570.9 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж, төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс дээд шатны төсвийн захирагч тухайн цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан 100,593.5 мянган төгрөгөөр бууруулан 1,078,977.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,078,977.4 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,078,977.4 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч, урсгал үйл ажиллагаанд 1,003,962.5 мянган төгрөгийг зарцуулж, 75,014.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,003,962.5 мянган төгрөг буюу 93.0 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 62,148.9 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл НДШ 11,464.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71701	Соёл урлаг	1,078,977.4	1,003,962.5	75,014.9	93.0
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,052,087.1	977,292.9	74,794.2	92.9
1.2	80205	Мэдээлэл сурталчилгаа	552.0	552.0	-	100.0
1.3	80814	Уран бүтээл хийлгэх	5,372.4	5,162.4	210.0	96.1
1.4	80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	9,217.5	9,217.5	-	100.0
1.5	80219	Харуул хамгаалалт	10,679.2	10,668.5	10.7	99.9
1.6	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	344.4	344.4	-	100.0
1.7	81909	Музей, түүх, соёлын өвийг сэргээх	724.8	724.8	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 90,218.9 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 50,054.5 мянга, нийт 140,273.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 73,456.1 мянга, цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардалд 18,367.2 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 4,714.3 мянга, түлш, халаалтын зардалд 2,232.1 мянга, эд хогшил худалдан авахад 3,848.9 мянга, хангамж, бараа материалын зардалд 31,469.9 мянга, бараа, үйлчилгээний бусад зардалд 330.0 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 1,111.2 мянга, нийт 135,529.8 мянган төгрөгийг зарцуулж, 3,893.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, 850.1 мянган төгрөгийн мөнгөний үлдэгдэлтэй гарсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монголын үндэсний музей нь үндсэн 61, гэрээт 10 ажилтантай, бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс, аюулгүй байдал, үйлчилгээний алба, боловсрол, олон нийтийн хөтөлбөр, маркетингийн алба, сан хөмрөгийн алба, эрдэм шинжилгээний төв, музей судлал, мэргэжил арга зүйн төв гэсэн албадаас бүрддэг.

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр, 6 арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 93.0 хувийн биелэлттэй байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд арга хэмжээний нээлт, танхимаар сургалтад 19,060.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Үндсэн үйл ажиллагаанаас /үзвэрийн тасалбарын/ орох орлогын төлөвлөгөө батлагдаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Монголын үндэсний музей 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-аар гаргуулан, 2022 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн. Гэвч “Санхүүгийн тооцоолох групп” ХХК санхүүгийн тайланг буруу гаргасан байна гэсэн үндэслэлээр Монголын үндэсний музейн нягтлан бодогч тайланг засаж, 2 дугаар сарын 17-нд ирүүлсэн. Засаж ирүүлсэн санхүүгийн тайлан нь алдаатай, журналууд дутуу байгаа талаар ахлах нягтлан бодогч, байгууллагын удирдлагад удаа дараа мэдэгдсэн боловч асуудал шийдэгдээгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 21 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Монголын үндэсний музей 2021 онд нийт 853,716.9 мянган төгрөгийн 149 мэдээг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 90,814.7 мянган төгрөгийн 13 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална” 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн төсөл боловсруулахдаа төсвийн байгууллагын үйл ажиллагаанаас орох орлогыг төлөвлөдөггүй, дээд шатны төсөв захирагч хянахдаа мөн нэмж батлаагүйгээс тасалбарын орлогыг нэмэлт санхүүжилтээр тайлагнаж байна.

Энэ нь Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан “Төсвийн зардлын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын “3.1. Үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогод дараах орлогыг тооцно: 3.1.1. Төлөвлөгөөнөөс давж биелсэн орлого, 3.1.2. Төсвийн жилийн дундуур шинээр бий болсон орлого”, 3.4. Энэ журмын 3.1.1-д заасан нэмэлт орлого бүрдүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг хориглоно: 3.4.3. Үндсэн үйл ажиллагааны буюу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог, жил бүр давтагддаг шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгахгүй орхигдуулах” заалтуудыг тус тус нийцээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 241,922.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 15 зөвлөмж өгсөн.

Өгсөн зөвлөмжүүдийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад журналууд бүрэн ирүүлээгүй учир алдаа зөрчлийг арилгасан эсэх талаар дүгнэх боломжгүй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,530.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 950.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 25,043.2 мянган төгрөгийн 3 зөвлөмж бүрэн хэрэгжиж, шилэн дансны цахим хуудсанд 28 мэдээг хугацаа хоцроож байршуулсан зөрчилд өгсөн 1 албан шаардлагын хэрэгжилт 93.3 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,530.0	1	1,530.0	-	-	100.0
Албан шаардлага	2	17,324.9	1	17,324.9	1	-	93.3
Зөвлөмж	3	25,043.2	3	25,043.2	-	-	100.0
Нийт дүн	5	32,687.5	4	32,687.5	1	-	97.7

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд алдаа зөрчлийг давтан гаргасан тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллага дээр ажиллаж, хөрөнгийн биет тооллого хийх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 129,694.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 78,908.4 мянган төгрөгийн 2 залруулга хийж, 1,969.8 мянган төгрөгийн 3 акт тогтоож, 48,815.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 7 зөвлөмж өгөв.

Залруулагдаагүй 50,785.7 мянган төгрөгийн алдаа, зөрчлийн дүн нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдал 14,178.9 мянган төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлэг 78,908.4 мянган төгрөгийг тохируулаагүй;
- “Түүх соёлын дурсгалт зүйлс” Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд тусгагдаагүй, үндсэн хөрөнгийн элэгдлийн журналд 3 нэрийн тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааг тогтоож элэгдэл бодуулаагүй, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө 120017 дансанд бүртгэх ёстой орлогыг 120045 дансанд бүртгэсэн, элэгдэлтэй шилжиж ирсэн хөрөнгийг анхны өртгөөр бүртгэж авсныг тус тус залруулав.

4.2 Төлбөрийн акт

Жилийн эцэст кассын орлогоос 850.1 мянган төгрөгийг харилцах дансанд төвлөрүүлээгүй байгаа нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Төсөвт байгууллагын мөнгөн кассын журам"-ын 6.1-д “Төсвийн байгууллагын кассад хэрэгцээнээс илүү мөнгө хадгалах явдлаас зайлсхийх үүднээс жижиг мөнгөн сангийн хэмжээг нарийвчлан төлөвлөж байна”, Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоол “Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.1. “Төсвийн тухай хуулийн 7.7, 44.6-г үндэслэн төсвийн жил дуусахад улсын төсвийн байгууллагын зарцуулаагүй дансны үлдэгдлийг улсын төсвийн дансанд, орон нутгийн төсвийн байгууллагын үлдэгдлийг тухайн орон нутгийн төсвийн дансанд, нийгмийн даатгалын төсвийн байгууллагын зарцуулаагүй дансны үлдэгдлийг нийгмийн даатгалын сангийн төсвийн дансанд оны сүүлийн ажлын өдрийн банк хоорондын сүлжээгээр хамгийн сүүлийн орлого татсаны дараа төрийн сангууд шууд татан төвлөрүүлнэ” заалттай нийцэхгүй, “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн жил дуусахад улсын төсвийн байгууллагын зарцуулаагүй дансны үлдэгдлийг улсын төсвийн дансанд төвлөрүүлээгүй тул төлбөрийн акт тогтоох.

Монгол банкны Мөнгөний музейг дэглэх ажил гүйцэтгэх гэрээний дагуу Монгол банкнаас орж ирсэн нэмэлт орлогоос гаднын байгууллагын 1 хүнд ажил гүйцэтгэх гэрээ байгуулалгүй, уг ажилд оролцсон нотлох баримтгүйгээр 866.2 мянган төгрөгийн урамшуулал олгосон байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” заалттай нийцэхгүй, “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хувь хүнээр ажил гүйцэтгүүлж ажлын хөлсийг гэрээ байгуулалгүй, нотлох баримтгүйгээр олгосонд төлбөрийн акт тогтоох.

Нэмэлт орлогоос 9 хоног ажилласан ахлах нягтлан бодогчид урамшуулалд 253.5 мянган төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах,” гэсэн заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажлын үр дүнг тооцоогүй ажилтанд урамшуулал олгосон тул төлбөрийн акт тогтоох.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Санхүүгийн тайланг 23 хоног хугацаа хоцроож, үндсэн хөрөнгө, бараа материалын журналаас бусад журналыг ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 8.9.1."төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх;" заалтыг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж:

Жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үр ашиг багатай 1 өдрийн Ухаант Цэцэнхүү арга хэмжээнд 12,000.0 мянга, Музейн бүтээлч үйлдвэрлэл сургалтад 6,050.0 мянга, "Боловсрол-100" үзэсгэлэнгийн нээлтэд 1,010.0 мянган төгрөг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.3."санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1. "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;" 1.6."Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

12 дугаар сард тушаал гарган ажилтнуудад үндсэн санхүүжилтээс ур чадварын нэмэгдэл 25 хувиар, урамшуулал 30-53 хувиар, нэмэлт санхүүжилтээс урамшуулал 100.0 хүртэл хувиар хавтгайруулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 5.1.3."санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ур чадварын нэмэгдлийн хавтгайруулан олгохгүй байх, Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

4. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нийт 61 ажилтнаас нэгжийн дарга нар, хүний нөөцийн болон санхүүгийн ажилтнуудад сар бүр зохих шалгуур үзүүлэлтээр дүгнэлгүйгээр тушаал гарган ур чадварын нэмэгдлийг олгодог нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 3. "Төрийн

үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно”, 4. “Энэ журмыг үндэслэн тухайн салбар, мэргэжлийн онцлогийг харгалзан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг салбарын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран тогтооно.” заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Салбарын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн нь соёлын салбарын ажилтнуудад /Төрийн албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдаас бусад/ ур чадварын нэмэгдэл олгох тухайн салбар, мэргэжлийн онцлогийг тусгасан шалгуур үзүүлэлтийг тогтоосон журам баталж гаргах хүртэл ур чадварын нэмэгдэл олгохгүй байх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

5. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 535,155.2 мянган төгрөгийн хөрөнгө байгаа нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох “ 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлээгүй, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгийн судалгаа гаргаж, холбогдох журмын дагуу ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох арга хэмжээ авч ажиллах.

6. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

"Барилга байгууламж"-д навчит мод, зүлэгжүүлсэн талбай, авто зогсоол, бетон талбайг бүртгэж, 48,392.6 мянган төгрөгийн хөрөнгийн ангилал буруу хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3."холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг хэрэгжүүлээгүй, "ангилал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийн ангилал холбогдох заавар журмын дагуу зөв бүртгэж, санхүүгийн тайланг үнэн зөв тайлагнаж байх.

7. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нэмэлт орлогоос захирал өөртөө тушаал гаргаж 423.3 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" гэсэн заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн зарцуулалттай холбоотой эрх зүйн актуудыг мөрдөн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

/мянган төгрөгөөр/

№	Байгуулагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга	Нийт алдаа зөрчил		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	МҮМ	АХГ-2022/198/НА-СТА-ТШЗ	Кассын орлогоос 850.1 мянган төгрөгийг харилцах дансанд төвлөрүүлээгүй.	Аудитын шалгалтын орлогын дансанд төвлөрүүлэх	1	850.1			1	850.1				
2	МҮМ	АХГ-2022/198/НА-СТА-ТШЗ	Санхүүгийн тайланг 23 хоног хугацаа хоцроосон. Бараа материал, үндсэн хөрөнгөөс бусад журналыг ирүүлээгүй.	Төсвийн тухай хуулийн 8.9.1-ийг хэрэгжүүлэх	1	0.0							1	0.0
3	МҮМ	АХГ-2022/198/НА-СТА-ТШЗ	Төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгээр иж бүрнээр бэлтгэж ирүүлээгүй, 78,908.4 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг тохируулаагүй	Төсвийн тухай хуулийн 54.5-ыг хэрэгжүүлэх	1	78,908.4	1	78,908.4						
4	МҮМ	АХГ-2022/198/НА-СТА-ТШЗ	Монгол банканд захиалгаар хийсэн ажлын төлбөрөөс гадны 1 хүнд уг ажилд оролцсон гэж гэрээ байгуулалгүй, нотлох баримтгүйгээр урамшуулал олгосон	Аудитын шалгалтын орлогын дансанд төвлөрүүлэх	1	866.2			1	866.2				
5	МҮМ	АХГ-2022/198/НА-СТА-ТШЗ	Нэмэлт орлогоос 9 хоног ажилласан ахлах нягтлан бодогчид 253.5 мянган төгрөгийн урамшуулал олгосон	Аудитын шалгалтын орлогын дансанд төвлөрүүлэх	1	253.5			1	253.5				
6	МҮМ	АХГ-2022/198/НА-СТА-ТШЗ	12 дугаар сард тушаал гарган ажилтнуудад үндсэн болон нэмэлт санхүүжилтээс урамшуулал 100.0 хүртэл хувиар, мөн ур чадварын нэмэгдэл хавтгайруулан олгосон.	Төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулах	1	0.0							1	0.0
7	МҮМ	АХГ-2022/198/НА-СТА-ТШЗ	Нийт 61 ажилтнаас нэгжийн дарга нар, хүний нөөцийн болон санхүүгийн ажилтнуудад сар бүр зохих шалгуур үзүүлэлтээр дүгнэлгүйгээр тушаал гарган ур чадварын нэмэгдлийг олгодог	Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4-р хавсралтын 4 дэх заалтыг мөрдөх	1	0.0							1	0.0

8	МҮМ	АХГ-2022/198/НА-СТА-ТШЗ	Үр ашиг багатай 1 өдрийн арга хэмжээнд, тухайлбал “Ухаант Цэцэнхүү” арга хэмжээнд 12,000.0 мянга, “Музейн бүтээлч үйлдвэрлэл” сургалтад 6,050.0 мянга, “Боловсрол – 100” үзэсгэлэнгийн нээлтэд 1,010.0 мянган төгрөг зарцуулсан ихээхэн зардал гаргаж байна.	төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулах	1	0.0							1	0.0
9	МҮМ	АХГ-2022/198/НА-СТА-ТШЗ	“Түүх соёлын дурсгалт зүйлс” Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүд татагдаагүй үндсэн хөрөнгийн элэгдлийн журналд 3 нэрийн тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааг тогтоож элэгдэл бодуулаагүй, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө 120017 дансанд бүртгэх ёстой орлогыг 1200045 дансанд бүртгэсэн, элэгдэлтэй шилжиж ирсэн хөрөнгийг анхны өртгөөр бүртгэсэн.	Залруулга хийх	1	0.0	1	0.0						
10	МҮМ	АХГ-2022/198/НА-СТА-ТШЗ	Нэмэлт орлогоос захирал өөртөө тушаал гаргаж 423.3 мянган төгрөгийн урамшуулал олгосон	Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөх	1	423.3							1	423.3
11	МҮМ	АХГ-2022/198/НА-СТА-ТШЗ	"Барилга байгууламж"-д 48,392.6 мянган төгрөгийн навчит мод, зүлэгжүүлсэн талбай, авто зогсоол, бетон талбайг бүртгэж, хөрөнгийн ангилал буруу хийсэн байна.	Хөрөнгийн ангилал зөв хийх зөвлөмж өгөх	1	48,392.6							1	48,392.6
12	МҮМ	АХГ-2022/198/НА-СТА-ТШЗ	Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 535,155.2 мянган төгрөгийн хөрөнгө байна.	Ашиглалтын хугацааг шинээр тогтоох	1	0.0							1	0.0
ДҮН					13	129,694.1	2	78,908.4	3	1,969.8			7	48,815.9
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал														
1	МҮМ	АХГ-2022/198/НА-СТА-ТШЗ	90,814.7 мянган төгрөгийн 13 мэдээллийг хугацаа хоцроосон.	Шилэн дансны хууль хэрэгжүүлэх	1	90,814.7						1	90,814.7	
ДҮН					1	90,814.7								
НИЙТ ДҮН					13	220,508.8	2	78,908.4	3	1,969.8	1	90,814.7	7	48,815.9



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2022 оны 02 дугаар сарын 25

№ 54 АО/0150458

Улаанбаатар хот

АХГ 2022/194/НА-СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд болон Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Монголын Үндэсний музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцэст кассын орлогоос 850,139.90 /найман зуун тавин мянга нэг зуун гучин есөн/ төгрөгийг харилцах дансанд төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоол "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.1. "Төсвийн тухай хуулийн 7.7, 44.6-г үндэслэн төсвийн жил дуусахад улсын төсвийн байгууллагын зарцуулаагүй дансны үлдэгдлийг улсын төсвийн дансанд, орон нутгийн төсвийн байгууллагын үлдэгдлийг тухайн орон нутгийн төсвийн дансанд, нийгмийн даатгалын төсвийн байгууллагын зарцуулаагүй дансны үлдэгдлийг нийгмийн даатгалын сангийн төсвийн дансанд оны сүүлийн ажлын өдрийн банк хоорондын сүлжээгээр хамгийн сүүлийн орлого татсаны дараа төрийн сангууд шууд татан төвлөрүүлнэ", Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төсөвт байгууллагын мөнгөн кассын журам"-ын 6.1 "Төсвийн байгууллагын кассад хэрэгцээнээс илүү мөнгө хадгалах явдлаас зайлсхийх үүднээс жижиг мөнгөн сангийн хэмжээг нарийвчлан төлөвлөж байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Улсын төсөвт төвлөрүүлээгүй 850,139.90 /найман зуун тавин мянга нэг зуун гучин есөн/ төгрөгийг, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкн дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монголын Үндэсний музейн захирал Л.Жаргал, нягтлан бодогч Ж.Батсүх нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Ч.МӨНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherig\Akt\2022\0225 Auditin 4 Gazar-56.Docx

001090181



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2022 оны 02 дугаар сарын 25

№ 55 А0/0130458

Улаанбаатар хот

АХГ 2022/194/НА-СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд болон Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Монголын Үндэсний музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монголбанкны Мөнгөний музейг дэглэх ажил гүйцэтгэх гэрээний дагуу Монголбанкнаас орж ирсэн нэмэлт орлогоос гадны байгууллагын 1 хүнд ажил гүйцэтгэх гэрээ байгуулалгүй, уг ажилд оролцсон нотлох баримтгүйгээр 866,200.00 төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Анхан шатны баримт бүрдэл дутуу, нотлох баримтгүйгээр олгосон 866,200.00 /найман зуун жаран зургаан мянга хоёр зуун/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монголын Үндэсний музейн захирал Л.Жаргал, нягтлан бодогч Ж.Батсүх нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Е.НАЦАГДОРЖ
Ч.МӨНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\0.10.10.20\Bichig_Khereg\Akt\2022\0225 Auditin 4 Gazar-57.Docx

001090183



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2022 оны 02 дугаар сарын 25

№ 56 А0/0150 458

Улаанбаатар хот

АХГ 2022/1194/НА-СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд болон Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Монголын Үндэсний музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын ахлах нягтлан бодогч 9 хоног ажилласан байхад 253,500.00 төгрөгийн үр дүнгийн урамшууллыг нэмэлт орлогоос олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нэмэлт орлогоос олгосон 253,500.00 /хоёр зуун тавин гурван мянга таван зуун/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монголын Үндэсний музейн захирал Л.Жаргал, нягтлан бодогч Ж.Батсүх нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


АУДИТЫН МЕНЕЖЕР

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

С.НАЦАГДОРЖ

Ч.МӨНХТУЯА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 291/А0150458
АХГ-2022/194/НА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Монголын Үндэсний музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд зөрчлийг давтан гаргаж шилэн дансны цахим мэдээллийн санд байршуулбал зохих 149 мэдээллээс 13 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "Тогтсон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 4.1.4 "хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3."Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, ил тод байдлыг ханган ажиллаж, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлага хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 03 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлэхийг Монголын Үндэсний музейн захирал Л.Жаргалд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


АУДИТЫН МЕНЕЖЕР

"УВАА УУЛ АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

С.НАЦАГДОРЖ

Ч.МӨНХТУЯА



0010800875

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for writing. The lines are evenly spaced across the entire page, providing a guide for letter height and placement. There is no text or other markings on the page.

[illegible]

[illegible]